

**СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 4 сарын 17 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

Хурал 2020 оны 04 сарын 27-ний өдрийн 14:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, 5/3 тоот Оффисын хоёрдугаар давхарын хурлын танхимд болов.

Хуралд оролцсон:

1. Г.Хатанболд /Хурлын дарга/
2. Г.Лхамсүрэн /Хувьцаа эзэмшигч/
3. Г.Ган-Эрдэнэ /Хувьцаа эзэмшигч/
4. Л.Золбаяр /Хувьцаа эзэмшигч/
5. Б.Эрдэнэжаргал /Хувьцаа эзэмшигч/
6. Н.Төгөлдөр /Тооллогын комиссын дарга/

Хурлын ирц:

Стандарт Проперти Групп ХК-ийн нийт гаргасан 1,627,807 ширхэг хувьцаа байгаагаас 1,627,807 ширхэг саналын эрхтэй хувьцаатай бөгөөд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2020 оны 04 сарын 7-ны өдрийн байдлаар нийт 103 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс 1,039,493 ширхэг, 29,342 ширхэг, 28,858 ширхэг, 22,342 ширхэг тус тус хувьцаатай 4 хувьцаа эзэмшигч буюу 68,81 хувийн ирцтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх хуралд ирсэн тул хурал хүчин төгөлдөрт тооцогдов. Оролцсон хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшил хувь
1	Ганболдын Лхамсүрэн	1,039,493	63.9%
2	Ганболдын Ган-Эрдэнэ	29,342	1.8%
3	Лхагвын Золбаяр	28,858	1.8%
4	Баярмагнайн Эрдэнэжаргал	22,342	1.4%
Нийт		1,120,035	68.81%

Хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 03-р сарын 18-ний өдрийн 2 тоот тогтоол болон хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг хэлэлцэх тухай.

Г.Хатанболд:

2019 онд үйл ажиллагаа явуулаагүй учраас борлуулалтын орлого, үйл ажиллагааны зардал гараагүй байна.

Л.Золбаяр: Компанийн нөхцөл байдлыг мэдэж байгаа болохоор үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг батлах саналтай байна.

Шийдвэр 1:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 2: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.

Г.Хатанболд: 2020 онд үйл ажиллагаа явуулахгүй учраас ТУЗ-н гишүүдэд цалин урамшуулал олгох боломжгүй байна.

Л.Золбаяр: Компани үйл ажиллагаа явуулж эхлэхээр цалин урамшуулал олгоно гэдэгт итгэж байна. Иймд энэхүү саналыг дэмжиж байна.

Шийдвэр 2:

1. Компани 2020 онд ТУЗ-ийн цалин, урамшуулал олгохгүй байхаар БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 3: ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай.

Г.Хатанболд: ТУЗ-ын гишүүдийг танилцууллаа.

Хараат бус гишүүд:

- С.Шагдарсүрэн
- Б.Амгаланбаатар
- Э.Пүрэвхам

Ердийн гишүүд:

- Г.Хатанболд
- Н.Улаанхүү
- Г.Лхамсүрэн
- Б.Хуяг
- Д.Баярсайхан
- М.Мөнхзолбоо

Г.Ган-Эрдэнэ: ТУЗ-ын гишүүдийг улируулан сонгохыг дэмжиж байна.

Л.Золбаяр: ТУЗ-ын гишүүдийг улируулан сонгохыг дэмжиж байна.

Шийдвэр 3:

1. Компанийн 2019 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгохыг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

Хараат бус гишүүдэд:

- С.Шагдарсүрэн
- Б.Амгаланбаатар
- Э.Пүрэвхам

Ердийн гишүүн

- Г.Хатанболд
- Г.Лхамсүрэн
- Д.Баярсайхан
- Н.Улаанхүү
- Б.Хуяг
- М.Мөнхзолбоо нарыг улируулан СОНГОСУГАЙ.

Хурлын дарга Г.Хатанболд хуралд оролцогсдод талархал илэрхийлж 15:20 цагт хурал өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:



Л.ГАНТУЯА

Танилцсан Хурлын дарга:

Г.ХАТАНБОЛД